



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: Р.Цолмон
Утас: 261628 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА
ТАНАА

2022.02.25 № 07/383
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,633,708,288.47</u>	<u>1,795,822,641.33</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	260,000.00	260,000.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	260,000.00	260,000.00
33	АВЛАГА	1,394,033,915.32	991,056,203.48
335	Бусад авлага	1,394,033,915.32	991,056,203.48
3351	Байгууллагаас авах авлага	1,394,033,915.32	991,056,203.48
34	УРЬДЧИЛГАА	72,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	72,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,167,414,373.15	804,506,437.85
351	Түүхий эд материал	748,016,950.00	227,030,501.04
35110	Тусгай зориулалттай материал	16,232,300.00	5,384,500.00
35130	Эм боох материал	731,784,650.00	221,646,001.04
354	Хангамжийн материал	419,397,423.15	577,475,936.81
35410	Бичиг хэргийн материал	10,879,485.00	16,528,833.00
35420	Аж ахуйн материал	6,661,360.00	10,626,379.00
35430	Сэлбэг хэрэгсэл	17,802,316.00	8,472,574.00
35440	Түлш, шатах тослох материал	9,522,168.00	4,663,830.84
35450	Барилгын засварын материал	5,949,900.00	6,604,900.00
35460	Хүнсний материал	976,180.00	520,190.00
35470	Бусад хангамжийн материал	367,606,014.15	530,059,229.97
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,005,830,453.31</u>	<u>1,796,006,290.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,005,830,453.31	1,796,006,290.78
392	Биет хөрөнгө	1,874,895,859.79	1,674,816,848.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,479,086,220.71	1,479,086,220.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(202,746,816.62)	(301,746,437.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,233,120.00	77,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,903,120.18)	(29,655,000.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,552,200,140.89	1,051,402,591.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,157,463,267.56)	(705,852,786.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	327,546,120.00	303,901,295.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(215,918,277.45)	(211,445,195.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,909,713.00	30,069,713.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,047,973.00)	(18,793,553.00)
393	Биет бус хөрөнгө	130,934,593.52	121,189,442.24
39301	Программ хангамж	86,019,698.55	86,019,698.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	(61,356,265.03)	(71,101,416.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	106,271,160.00	106,271,160.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,639,538,741.78</u>	<u>3,591,828,932.11</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,639,538,741.78</u>	<u>3,591,828,932.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,639,538,741.78	3,591,828,932.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,390,485,153.08	2,390,485,153.08
51101	Өмч: - төрийн	2,390,485,153.08	2,390,485,153.08
512	Хуримтлагдсан үр дүн	1,384,583,257.40	336,873,447.73
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,053,816,242.51)	1,384,583,257.40
51220	Тайлант үеийн үр дүн	2,443,167,655.91	(1,047,709,809.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,470,331.30	864,470,331.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,639,538,741.78</u>	<u>3,591,828,932.11</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,877,785,995.39	27,307,702,573.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,638,257,840.79	1,851,190,969.88
120	Нийтлэг татварын бус орлого	2,638,257,840.79	1,851,190,969.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,633,577,840.79	1,847,390,969.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	906,142,904.00	262,660,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	96,983,066.00	101,020,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,630,451,870.79	1,483,710,969.88
120009	Бусад орлого	4,680,000.00	3,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,239,528,154.60	25,456,511,603.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,628,267,200.00	22,939,376,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,628,267,200.00	22,939,376,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,611,260,954.60	2,517,135,503.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	64,518,000.00	440,882,722.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,813,112,000.00	1,881,227,260.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	733,630,954.60	195,025,521.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,379,011,789.84	26,318,976,707.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,379,011,789.84	26,318,976,707.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,523,604,973.28	25,278,337,702.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,940,351,064.80	17,713,890,317.09
210101	Үндсэн цалин	1,700,216,641.19	17,171,512,171.02
210102	Нэмэгдэл	36,334,423.61	318,923,121.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	147,413,523.00
210104	Урамшуулал	203,800,000.00	76,041,501.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,629,750.30	2,238,091,518.61
210201	Тэтгэврийн даатгал	119,424,648.30	1,577,466,896.80
210202	Тэтгэмжийн даатгал	13,929,369.00	167,159,482.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,794,054.00	125,412,898.22
210204	Ажилгүйдлийн даатгал	2,589,245.00	33,691,630.79
210205	Эрүүл мэндийн даатгал	25,892,434.00	334,360,610.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,777,094.21	121,028,056.47
210301	Гэрэл, цахилгаан	42,379,457.48	41,372,990.86
210302	Түлш, халаалт	25,661,501.81	32,231,969.62
210303	Цэвэр, бохир ус	23,736,134.92	47,423,095.99
2104	Хангамж, бараа материалын зардал	114,379,284.55	141,127,246.77
210401	Бичиг хэрэг	28,447,615.00	27,208,965.00
210402	Тээвэр, шатахуун	21,829,737.00	23,188,264.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,146,988.55	19,144,869.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,010,720.00	21,925,054.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,944,224.00	18,912,333.00
210408	Бараа материал акталсны зардал	-	25,316,411.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	5,431,350.00
2105	Нормативт зардал	345,987,200.00	1,170,164,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,799,200.00	1,161,579,570.00
210502	Хоол, хүнс	2,508,000.00	8,520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,680,000.00	65,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	283,301,932.00	97,060,733.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,380,000.00	6,864,142.00
210602	Тавилга	-	29,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,846,900.00	765,000.00
210604	Урсгал засвар	230,075,032.00	89,401,691.00
2107	Томилолт, зочны зардал	99,255,112.00	115,234,800.00
210702	Дотоод албан томилолт	99,255,112.00	115,234,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	542,569,687.86	906,520,709.43

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	488,867,153.86	804,304,495.43
210803	Даатгалын үйлчилгээ	1,655,120.00	474,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,400.00	455,440.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,298.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,091,750.00	12,911,700.00
210807	Газрын төлбөр	1,670,404.00	1,670,194.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	24,989,562.00	86,538,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,933,353,847.56	2,775,219,750.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,901,398.00	320,474,786.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,562,972,623.00	2,224,608,935.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	263,479,826.56	230,136,028.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	855,406,816.56	1,040,639,005.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	803,653,165.67	1,016,376,871.44
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	779,804,765.67	971,932,103.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,768,400.00	43,844,768.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,080,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,753,650.89	24,262,133.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,753,650.89	24,262,133.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,498,774,205.55	988,725,866.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,055,606,549.64	2,036,435,675.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	107,811,132.57
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,055,606,549.64	1,928,624,543.18
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,055,606,549.64)	(2,036,435,675.75)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,443,167,655.91	(1,047,709,809.67)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	(1,053,816,242.51)	2,201,139,241.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(4,768,156.00)	(4,768,156.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	(1,058,584,398.51)	2,196,371,085.87
Өмчид гарсан өөрчлөлт			2,443,167,655.91	2,443,167,655.91
Зарласан ноогдол ашиг	2,390,485,153.08	864,470,331.30	1,384,583,257.40	4,639,538,741.78
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	1,384,583,257.40	4,639,538,741.78
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	1,384,583,257.40	4,639,538,741.78
Тайлант үеийн үр дүн			(1,047,709,809.67)	(1,047,709,809.67)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	336,873,447.73	3,591,828,932.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,247,334,124.60	26,575,550,518.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,007,805,970.00	367,480,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,007,805,970.00	367,480,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,007,805,970.00	363,680,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	906,142,904.00	262,660,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,663,066.00	101,020,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,239,528,154.60	26,208,070,518.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,628,267,200.00	22,939,376,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,628,267,200.00	22,939,376,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,611,260,954.60	3,268,694,418.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	64,518,000.00	440,882,722.50

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,813,112,000.00	2,632,786,175.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	733,630,954.60	195,025,521.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,061,020,169.60	26,486,738,519.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,061,020,169.60	26,486,738,519.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,402,983,222.72	24,810,043,311.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,884,184,349.80	17,713,890,317.09
210101	Үндсэн цалин	1,077,712,813.19	17,159,181,508.86
210102	Нэмэгдэл	284,446,836.61	319,888,958.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	129,888,000.00	154,039,584.52
210104	Урамшуулал	392,136,700.00	80,780,265.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,644,700.00	2,238,091,518.61
210201	Тэтгэврийн даатгал	114,453,700.00	1,577,466,896.80
210202	Тэтгэмжийн даатгал	12,047,800.00	167,159,482.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,638,200.00	125,412,898.22
210204	Ажилгүйдлийн даатгал	2,409,500.00	33,691,630.79
210205	Эрүүл мэндийн даатгал	24,095,500.00	334,360,610.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,777,094.21	121,028,056.47
210301	Гэрэл, цахилгаан	42,379,457.48	41,372,990.86
210302	Түлш, халаалт	25,661,501.81	32,231,969.62
210303	Цэвэр, бохир ус	23,736,134.92	47,423,095.99
2104	Хангамж, бараа материалын зардал	136,403,997.55	107,998,649.77
210401	Бичиг хэрэг	32,038,168.00	21,051,113.00
210402	Тээвэр, шатахуун	19,270,800.00	17,236,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,048,988.55	17,351,869.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,841,660.00	24,950,533.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,204,381.00	27,408,834.00
2105	Нормативт зардал	727,668,000.00	904,115,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	721,722,500.00	893,335,510.00
210502	Хоол, хүнс	2,448,000.00	8,520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,497,500.00	2,260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	754,703,270.00	90,571,518.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	472,084,900.00	3,652,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	44,911,200.00	-
210604	Урсгал засвар	237,707,170.00	86,889,418.00
2107	Томилолт, зочны зардал	99,255,112.00	116,234,800.00
210702	Дотоод албан томилолт	99,255,112.00	116,234,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	802,817,108.16	1,032,248,219.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	512,208,054.16	808,036,325.43
210803	Даатгалын үйлчилгээ	1,655,120.00	474,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,400.00	455,440.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,298.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,091,750.00	167,911,700.00
210807	Газрын төлбөр	1,670,404.00	1,670,194.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	61,896,082.00	53,534,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,743,529,591.00	2,485,864,721.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,808,798.00	320,474,786.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,637,720,793.00	2,165,389,935.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,658,036,946.88	1,676,695,208.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	854,724,380.67	1,016,376,871.44
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	830,875,980.67	971,932,103.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,768,400.00	43,844,768.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,080,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	803,312,566.21	660,318,337.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,753,650.89	24,262,133.73
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	751,558,915.32	636,056,203.48
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	186,313,955.00	88,811,999.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	186,053,955.00	88,811,999.00

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	186,053,955.00	88,811,999.00
2200	Дотоод эх үүсвэрээр	186,053,955.00	88,811,999.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	186,053,955.00	88,811,999.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(186,053,955.00)	(88,811,999.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	260,000.00	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	260,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	260,000.00	260,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,299,576,100.00	23,303,056,100.00	(3,480,000.00)	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,299,576,100.00	23,278,793,966.27	20,782,133.73	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,935,631,500.00	22,917,953,917.83	17,677,582.17	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,576,331,400.00	17,576,260,628.45	70,771.55	100.0
210101	Үндсэн цалин	17,094,933,400.00	17,094,893,514.29	39,885.71	100.0
210102	Нэмэгдэл	251,361,700.00	251,361,685.47	14.53	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	154,067,200.00	154,039,584.52	27,615.48	100.0
210104	Урамшуулал	75,969,100.00	75,965,844.17	3,255.83	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,240,314,300.00	2,238,091,518.61	2,222,781.39	99.9
210201	Тэтгэврийн даатгал	1,577,467,000.00	1,577,466,896.80	103.20	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	167,159,600.00	167,159,482.11	117.89	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	125,413,000.00	125,412,898.22	101.78	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	33,798,500.00	33,691,630.79	106,869.21	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	336,476,200.00	334,360,610.69	2,115,589.31	99.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,010,200.00	121,028,056.47	2,982,143.53	97.6
210301	Гэрэл, цахилгаан	44,354,200.00	41,372,990.86	2,981,209.14	93.3
210302	Түлш, халаалт	32,232,600.00	32,231,969.62	630.38	100.0
210303	Цэвэр, бохир ус	47,423,400.00	47,423,095.99	304.01	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	101,100,600.00	99,903,649.77	1,196,950.23	98.8
210401	Бичиг хэрэг	16,404,800.00	16,196,113.00	208,687.00	98.7
210402	Тээвэр, шатахуун	14,040,000.00	13,996,300.00	43,700.00	99.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,435,000.00	17,351,869.27	83,130.73	99.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,065,300.00	24,950,533.50	114,766.50	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,155,500.00	27,408,834.00	746,666.00	97.3
2105	Норматив зардал	235,020,600.00	234,960,600.00	60,000.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	232,760,600.00	232,700,600.00	60,000.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,260,000.00	2,260,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	132,963,400.00	132,717,299.00	246,101.00	99.8
210601	Багаж, техник хэрэгсэл	68,695,000.00	68,658,899.00	36,101.00	99.9
210604	Урсгал засвар	64,268,400.00	64,058,400.00	210,000.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	22,286,600.00	21,710,700.00	575,900.00	97.4
210702	Дотоод албан томилолт	22,286,600.00	21,710,700.00	575,900.00	97.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,826,200.00	488,614,599.43	9,211,600.57	98.1

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,065,100.00	264,402,705.43	6,662,394.57	97.5
210803	Даатгалын үйлчилгээ	475,000.00	474,960.00	40.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,500.00	455,440.00	40,060.00	91.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	185,100.00	165,000.00	20,100.00	89.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	169,760,000.00	167,911,700.00	1,848,300.00	98.9
210807	Газрын төлбөр	1,670,500.00	1,670,194.00	306.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	54,175,000.00	53,534,600.00	640,400.00	98.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,005,778,200.00	2,004,666,866.10	1,111,333.90	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,022,000.00	17,021,986.00	14.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,988,756,200.00	1,987,644,880.10	1,111,319.90	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	363,944,600.00	360,840,048.44	3,104,551.56	99.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	363,944,600.00	360,840,048.44	3,104,551.56	99.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	319,499,800.00	316,395,280.00	3,104,520.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,844,800.00	43,844,768.44	31.56	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	-	100.0
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		24,262,133.73	(24,262,133.73)	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО			-	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,299,576,100.00	23,303,056,100.00	(3,480,000.00)	100.0
122005	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,939,376,100.00	22,939,376,100.00	-	100.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлого	260,200,000.00	262,660,000.00	(2,460,000.00)	100.9
1E+06	Туслах үйл ажиллагааны орлого	100,000,000.00	101,020,000.00	(1,020,000.00)	101.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	84	84	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	78	78	-	
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөг/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)		3,272,494,418.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,272,494,418.82
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,980,901,392.34
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		137,629,688.64
210101	Үндсэн цалин		64,287,994.57
210102	Нэмэгдэл		68,527,272.69
210104	Урамшуулал		4,814,421.38
2104	Хангамж, бараа материалын зардал		8,095,000.00
210401	Бичиг хэрэг		4,855,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,240,000.00
2105	Нормативт зардал		669,154,910.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		660,634,910.00
210502	Хоол, хүнс		8,520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		46,666,218.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		14,871,800.00
210602	Тавилга		8,963,400.00
210604	Урсгал засвар		22,831,018.00
2107	Томилолт, зочны зардал		94,524,100.00
210702	Дотоод албан томилолт		94,524,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		543,633,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		543,633,620.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		481,197,855.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		303,452,800.20
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		177,745,055.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,291,593,026.48
2132	Бусад урсгал шилжүүлэг		655,536,823.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		655,536,823.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		636,056,203.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		636,056,203.48
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)		3,272,494,418.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,800,000.00
1200	Нийтлэг татварын бус орлого		3,800,000.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого		3,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,268,694,418.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,268,694,418.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		440,882,722.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х		2,632,786,175.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		195,025,521.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		260,000.00
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		260,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын амбулаторын үзлэгийн цаг товлох үйлчилгээг зохицуулах замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тайлант оны хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,434,618.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 168,692.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 134,953.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,047,709.8 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү 3=2-1
	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,633,708.3	1,795,822.6	(837,885.7)
Мөнгөн хөрөнгө	260.0	260.0	0.0
Авлага	1,394,033.9	991,056.2	(402,977.7)
Урьдчилгаа	72,000.0		
Бараа материал	1,167,414.4	804,506.4	(362,908.0)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,005,830.5	1,796,006.3	(209,824.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,639,538.7	3,591,828.9	(1,047,709.8)
Засгийн газрын хувь оролцоо	4,639,538.7	3,591,828.9	(1,047,709.8)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,639,538.7	3,591,828.9	(1,047,709.8)

Материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны 260.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь ахмадын сангийн үлдэгдэлтэй.
- Авлагын данс 402,977.7 мянган төгрөгөөр буурсан нь Коронавируст халдвар цар тахлын эрсдэлээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийг дэмжих төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж авч, дэмжих төвүүдэд олгосон, мөн нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн үлдэгдлээ буцаан авсан шалтгаанаар буурсан.
- Урьдчилж гарсан зардал данс 72,000.0 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилгаа санхүүжилт байсан ба энэ онд ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.
- Бараа материалын дансны үлдэгдэл урьд оноос 362,907.9 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материал 1,368,618.7 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,353,514.5 мянган төгрөгийг Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын үед тусгаарлах байранд ажиллаж байгаа резидент эмч нарт олгох нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлд зарцуулсан.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 209,824.2 мянган төгрөгөөр буурсан нь эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар байгуулагдсантай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 53 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,047,709.8 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны урсгал зардлын санхүүжилтэд 5,900,478.5 мянган төгрөг, зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж баталсан байна.

2020 оны 12 дугаар сард ЭМС-ын А/226 дугаар тушаалаар Резидент эмч нарт цалин олгох шийдвэр гарч, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төсөвт тодотгол хийж, 18,371,858.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 24,272,337.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсөвт 2021 оны 12 дугаар сард тодотгол хийж, урсгал зардлыг 23,299,576.1 мянган төгрөгийн 22,939,376.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 360,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг улсын төсвөөс 22,939,376.1 мянган төгрөг, өөрийн орлогоор 360,200.0 мянган төгрөг, нийт 23,299,576.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 23,303,056.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны урсгал зардалд 22,917,953.9 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 360,840.1 мянган төгрөг зарцуулж, 24,262.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 23,303,056.1 мянган төгрөг зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалд 19,814,352.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,004,666.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 488,614.6 мянган төгрөг, бараа материал, байр

ашиглалт, нормативт зардал зэрэгт 971,160.4 мянган төгрөгийг зарцуулж, 24,262.1 мянган төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	18,410,403.8	18,410,403.6	0.2	99.9
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	18,410,403.8	18,410,403.6	0.2	99.9
2	71603	Эрүүл мэндийн бодлого удирдлага	4,618,912.3	4,594,650.4	24,261.9	99.4
2.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	4,018,804.2	4,004,305.8	14,498.4	99.6
2.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	53,400.0	50,010.0	3,390.0	93.6
2.3	80221	Гэрээт ажиллагсдын зардал	75,801.5	72,532.6	3,268.9	95.6
2.4	80307	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох	17,022.0	17,022.0	0.0	99.9
2.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	363,944.6	360,840.0	3,104.6	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 440,882.7 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 2,632,786.2 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 195,025.5 мянган, нийт 3,268,694.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тусгаарлах байранд ажилласан резидент эмч, ковидын үед илүү цагаар ажилласан албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 137,629.7 мянган, хангамжийн материал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолтын зардал зэрэгт 818,440.2 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардал, бараа үйлчилгээний зардалд 1,024,831.5 мянган, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 655,536.8 мянган, нийт 2,636,438.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 636,056.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн улсын төсвийн санхүүжилт өмнөх оныхоос 17,311,108.9 мянган төгрөгөөр өссөн нь резидент эмч нарт цалин олгодог болсонтой холбоотой байна. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эмнэлгийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан ажлын хүрээнд резидент эмч нар тодорхой үүрэг, оролцоотой ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 209 мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 195 мэдээллийг хугацаандаа, 646,520.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож, 111,385.7 мянган төгрөгийн 9 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 албан шаардлагын хэрэгжилт 67.0 хувьтай байна. Энэ нь дээд шатны төсөв захирагч Эрүүл мэндийн яамнаас шийдвэрлэх асуудлууд байгаа тул дараагийн шатны аудитаар авч үзэх болно.

Хүснэгт-3

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	37.0	2	31.6	1	5.4	67.0
Нийт дүн	3	37.0	2	31.6	1	5.4	67.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Резидент эмч нарын цалингийн санхүүжилтийн талаар холбогдох авч хэрэгжүүлсэн арга ажилласан эсэх талаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 159,768.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,768.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 155,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 4,768.2 мянган төгрөгийн номын фондыг үндсэн хөрөнгөөс хасаж, өмнөх оны үр дүнд бичсэнийг залруулж, эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэсэн.

4.2 Албан шаардлага

Тайлант онд Эрүүл мэндийн статистик мэдээ, тайлангийн H-info программын эмнэлгийн хуудсыг E-mongolia төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас олгох, программ хөгжүүлэлтийн ажлыг хийлгүүлэхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 22-нд гэрээг байгуулж, гүйцэтгэгч компанид ажлын хөлс болох 155,000,000.00 төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай-ийн “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ нь 40 дүгээр зүйлийн 40.3-т “Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас

гадна дараах нөхцөлийг заавал тусгана", 40 дүгээр зүйлийн 40.3.7-д бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь" заалтуудыг мөрдөж ажиллах.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 1062 удаагийн 4,602,626.8 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 3,114,490.3 мянган төгрөгийн НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах" заалттай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ бэлтгэн нийлүүлэгчээс төлбөрийн цахим баримтыг гаргуулан авах, анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл хөтөлж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/226 тушаалаар баталсан "Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам"-д заасны дагуу 2021 оноос резидент эмч нарт олгож, санхүүжилтийг тус төвөөс эмнэлгүүдэд хуваарилсан байна. Санхүүжилтийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан хяналтын тоонд багтааж, сургалт эрхэлсэн байгууллагад сар бүр шилжүүлж, жилийн эцэст тооцоо нийлсэн байна. Тооцоо нийлэхдээ тухайн эрүүл мэндийн байгууллага нь гүйцэтгэлээр хэдэн төгрөгийн цалин олгосныг тооцолгүй, эмнэлгүүдэд олгосон санхүүжилтэд үндэслэсэн акт үйлдсэн байна. Энэ нь тухайн эмнэлгүүдэд илүү санхүүжилт олгож, төсвийг үргүй зарцуулах эрсдэлтэй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Сургалт эрхэлсэн байгууллагатай тооцоо нийлэхдээ резидент эмч нарт гүйцэтгэлээр олгосон цалингийн дүнг хянаж, баталгаажуулах, холбогдох журамд тусгуулж бодит арга хэмжээ авах.

Бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны баримтыг цахим баримтаар авч байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөг/							
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
					Тоо	Дүн	Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батламж мэдэгдлийн түвшинд												
1	Эрүүл мэндийн хөгжлийн төв	АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ	Номын фондыг эргэлтийн бус хөрөнгөнд	Залруулсан	1	4,768.2	1	4,768.2		-	-	-
2	Эрүүл мэндийн хөгжлийн төв	АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ	Гэрээт ажлын явц дүгнэгдээгүй байхад төлбөрийг 100 хувь шилжүүлсэн байна.	Албан шаардлага	1	155,000.0	-	-	1	155,000.0	-	-
3	Эрүүл мэндийн хөгжлийн төв	АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ	Санхүүжилт олгохдоо анхан шатны баримтын бүрдэл хангах, гүйцэтгэлийг хянах, хяналтаа сайжруулах	Зөвлөмж	1	-	-	-	-	-	1	-
5	Эрүүл мэндийн хөгжлийн төв	АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтыг цахим баримтаар авч байх	Зөвлөмж	1	-	-	-	-	-	1	-
Санхүүгийн тайлангийн түвшинд												
4	Эрүүл мэндийн хөгжлийн төв	АХГ-2022/380/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Зөвлөмж	1	-	-	-	-	-	1	-
Дүн					5	159,768.2	1	4,768.2	1	155,000.0	3	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 67/АД/40083
АХГ-2022/980/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу хийсэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн статистик мэдээ, тайлангийн H-info программын эмнэлгийн хуудсыг E-mongolia төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас олгох, программ хөгжүүлэлтийн ажлыг хийлгүүлэхээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 22-нд гэрээ байгуулж, гүйцэтгэгч компанид ажлын хөлс болох 155,000,000.00 төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана", мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.7 "Бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, нягтлан бодогч Б.Очир нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Р.ЦОЛМОН
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264210

110.10.10.20/Bichig_Kherag/Alban_Shaardlaga/2022/0225 Auditin 2 Gazar-89.Docx

01

0010800289

САНАЛ ДҮГҮЭЛТ

[illegible]

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс